



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/162


Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Тус албаны болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа байгууллагуудын удирдах ажилтан, албан хаагчдын дунд ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр **"Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв"** сэдэвт сургалт зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

2. Сургалтын 2 цагийн хөлс болох 100000 /нэг зуун мянга/-н төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР